



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/145/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас:99125777 Цахим хаяг: azzayats@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.02.23 № 1/63
танай _____ -ны № _____ -т

ҮЕНЧ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Т.ТОГТОХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэг нь 7.2 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар, 20.0 сая төгрөгийн их засварын ажлыг сумын ОНХС-аас, бусад эх үүсвэрээс 70.0 сая төгрөгийн барилга байгууламжийг хүлээн авч бүртгэлд тусгажээ.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Үенч сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд 7 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, 96 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>38,064,867.90</u>	<u>40,961,865.48</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	267,388.50	21,524,672.48
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	267,388.50	21,524,672.48
3121	Төгрөг	267,388.50	21,524,672.48
31211	Төрийн сангийн харилцах	267,388.50	21,524,672.48
33	АВЛАГА	3,086,293.00	2,838,993.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,838,993.00	2,838,993.00
335	Бусад авлага	247,300.00	-
3351	Байгууллагаас авах авлага	247,300.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	34,711,186.40	16,598,200.00
351	Түүхий эд материал	26,254,286.40	9,790,700.00
35110	Тусгай зориулалттай материал	26,254,286.40	9,790,700.00
354	Хангамжийн материал	8,456,900.00	6,807,500.00
35460	Хүнсний материал	5,215,800.00	-
35470	Бусад хангамжийн материал	3,241,100.00	6,807,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>886,787,462.63</u>	<u>981,713,839.49</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	886,787,462.63	981,713,839.49
392	Биет хөрөнгө	874,787,462.63	969,713,839.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	878,469,411.83	968,469,411.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,646,650.75)	(71,772,276.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,451,521.00	57,896,676.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,257,703.96)	(29,936,799.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,415,267.03	76,990,267.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,626,884.32)	(38,446,140.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,396,023.00	9,396,023.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,637,809.20)	(6,107,610.40)
39217	Ном	3,224,288.00	3,224,288.00
393	Биет бус хөрөнгө	12,000,000.00	12,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,000,000.00	12,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>924,852,330.53</u>	<u>1,022,675,704.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,318,367.89</u>	<u>3,291,163.37</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,318,367.89	3,291,163.37
413	Өглөг	1,318,367.89	3,291,163.37
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,318,367.89	0.10
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,291,163.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>923,533,962.64</u>	<u>1,019,384,541.60</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	923,533,962.64	1,019,384,541.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,504,224.00	122,504,224.00
51101	Өмч: - төрийн	122,504,224.00	122,504,224.00
512	Хуримтлагдсан үр дүн	427,448,487.64	523,299,066.60
51210	Өмнөх үеийн үр дүн	427,448,487.64	427,448,487.64
51220	Тайлант үеийн үр дүн	-	95,850,578.96

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	373,581,251.00	373,581,251.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	924,852,330.53	1,022,675,704.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	605,521,513.00	964,827,355.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,223,013.00	131,331,655.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,223,013.00	131,331,655.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,223,013.00	4,455,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,455,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,223,013.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		118,950,155.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		7,926,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	598,298,500.00	833,495,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	551,542,200.00	773,631,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,963,700.00	773,631,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	520,578,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,756,300.00	59,864,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,756,300.00	59,864,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	630,931,392.80	868,976,776.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,931,392.80	868,976,776.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,323,034.10	855,757,576.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,485,171.28	529,555,843.23
210101	Үндсэн цалин	373,237,871.28	376,355,198.40
210102	Нэмэгдэл	247,300.00	108,776,698.84
210104	Урамшуулал	-	44,423,945.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,735,235.43	67,353,600.00
210201	Тэтгэврийн даатгал	45,735,235.43	43,530,085.20
210202	Тэтгэмжийн даатгал	-	9,189,034.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,154,875.47
210204	Ажилгүйдлийн даатгал	-	941,490.24
210205	Эрүүл мэндийн даатгал	-	9,538,114.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,557,899.30	61,945,763.27
210301	Гэрэл, цахилгаан	3,197,300.00	7,287,763.27
210302	Түлш, халаалт	54,360,599.30	54,498,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	160,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	528,000.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	528,000.00	-
2105	Нормативт зардал	85,591,722.00	104,441,125.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,100.00	-
210502	Хоол, хүнс	84,591,622.00	104,441,125.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,109,500.00	1,121,400.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,109,500.00	1,121,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,315,506.09	91,339,844.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,264,100.00	58,883,366.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,821,900.00	4,362,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,229,506.09	28,093,778.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,608,358.70	13,219,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,520,400.00	13,219,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,520,400.00	13,219,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,087,958.70	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,087,958.70	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(25,409,879.80)	95,850,578.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(25,409,879.80)	95,850,578.96

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	122,504,224.00	373,581,251.00	(488,237,106.53)	7,848,368.47
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,504,224.00	373,581,251.00	(488,237,106.53)	7,848,368.47
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	915,685,594.17	915,685,594.17
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224.00	373,581,251.00	427,448,487.64	923,533,962.64
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,504,224.00	373,581,251.00	427,448,487.64	923,533,962.64
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,504,224.00	373,581,251.00	427,448,487.64	923,533,962.64
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	95,850,578.96	95,850,578.96
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,504,224.00	373,581,251.00	523,299,066.60	1,019,384,541.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	598,298,500.00	837,950,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,455,000.00

120	Нийтлэг татварын бус орлого	-	4,455,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,455,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,455,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	598,298,500.00	833,495,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	551,542,200.00	773,631,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	30,963,700.00	773,631,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	520,578,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,756,300.00	59,864,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,756,300.00	59,864,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	597,947,211.10	816,693,416.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	597,947,211.10	816,693,416.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582,338,852.40	803,474,216.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359,428,481.10	536,174,611.02
210101	Үндсэн цалин	277,377,350.49	368,009,140.25
210102	Нэмэгдэл	64,811,123.06	137,901,945.87
210104	Урамшуулал	17,240,007.55	30,263,524.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,117,422.00	67,353,600.00
210201	Тэтгэврийн даатгал	33,588,300.00	45,800,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,850,000.00	5,388,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,141,000.00	4,310,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,746,322.00	1,077,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,791,800.00	10,776,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,957,899.30	58,894,600.00
210301	Гэрэл, цахилгаан	3,197,300.00	3,996,600.00
210302	Түлш, халаалт	54,360,599.30	54,498,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2105	Нормативт зардал	85,662,850.00	108,629,325.00
210502	Хоол, хүнс	85,662,850.00	108,629,325.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,180,000.00	970,000.00
210604	Урсгал засвар	1,180,000.00	970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,109,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,109,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,882,700.00	31,452,080.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,189,900.00	27,384,580.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,692,800.00	4,067,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,608,358.70	13,219,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,520,400.00	13,219,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,520,400.00	13,219,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,087,958.70	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,087,958.70	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	351,288.90	21,257,283.98
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	351,288.90	21,257,283.98
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		267,388.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	267,388.50	21,524,672.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	838,218,088.50	816,693,416.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	838,218,088.50	816,693,416.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	824,998,888.50	803,474,216.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,843,388.50	536,174,611.02
210101	Үндсэн цалин	371,352,000.00	368,009,140.25
210102	Нэмэгдэл	151,645,688.50	137,901,945.87
210104	Урамшуулал	25,845,700.00	30,263,524.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,572,100.00	67,353,600.00
210201	Тэтгэврийн даатгал	46,629,300.00	45,800,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,485,900.00	5,388,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,388,500.00	4,310,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,097,300.00	1,077,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,971,100.00	10,776,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,594,600.00	58,894,600.00
210301	Гэрэл, цахилгаан	6,696,600.00	3,996,600.00
210302	Түлш, халаалт	54,498,000.00	54,498,000.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2105	Нормативт зардал	110,474,600.00	108,629,325.00
210502	Хоол, хүнс	110,474,600.00	108,629,325.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	970,000.00	970,000.00
210604	Урсгал засвар	970,000.00	970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,355,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,355,800.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,188,400.00	31,452,080.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,120,900.00	27,384,580.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,067,500.00	4,067,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,219,200.00	13,219,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,219,200.00	13,219,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,219,200.00	13,219,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	838,218,088.50	837,950,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	773,631,100.00	773,631,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	773,631,100.00	773,631,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,864,600.00	59,864,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	59,864,600.00	59,864,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	4,455,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,455,000.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	4,455,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	4,455,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		267,388.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,524,672.48

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант онд нэмэлт дансаар санхүүжилт аваагүй байна.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,763.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрч 8,031.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж баталгаажуулав.

Үүнд:

- Хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгүүдийг бүртгэлд авахдаа давхардуулан 2 бүртгэж авсантай холбоотой 8,031.1 мянган төгрөгийн хөрөнгө илүү бүртгэгдсэнийг залрууллаа.

3.1 ТӨЛБӨРИЙН АКТ

- Ур чадварын нэмэгдлийг 518.0 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Залруулагдаагүй 2 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар 3 зөрчил² илэрснээс, 518.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 6,213.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Бараа материалын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Тайлант онд зарцуулсан шатахууны зарцуулалтын тооцоо бодоогүй, замын хуудас бичүүлж хяналт хэрэгжүүлэхгүй зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн замын хуудас бичүүлж, шатахууны зарцуулалтыг сар, улирлаар тооцоо бодож баталгаажуулж ажиллах.

2. **Авлагын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Насжилт өндөртэй авлагыг эзэн холбогдогчийг тодорхойлж барагдуулах арга хэмжээ аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: 2024 онд авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Үенч сумын Хүүхдийн цэцэрлэг	Хөрөнгө илүү бүртгэсэн	1	8,031.1			1	8,031.1	1	8,031.1				
Нийт дүн		1	8,031.1			1	8,031.1	1	8,031.1				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Үенч сумын Хүүхдийн цэцэрлэг	Ур чадварын нэмэгдлийг илүү тооцон олгосон.	1	518.0	1	518.0						
	Тайлант онд зарцуулсан шатахууны тооцоог анхан шатны баримтад үндэслэн бодоогүй	1	3,375.0					1	3,375.0		
	Насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй	1	2,838.9					1	2,838.9		
Нийт дүн		3	6,731.9	1	518.0			2	6,213.9		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан				

A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТК								
5	ТЕЗ								
	Нийт	1	1			1			